

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Аудитын код: САГ-2019/146/СТА-ТШЗ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
	3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
	3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
	3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
	3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/449
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Удирдлагын академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Удирдлагын академийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Удирдлагын академийн захирал С.Зулпхар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 7-ноос 2019 оны 3 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл, чанарын хяналтын менежер Ч.Чимгээ, аудиторын туслах Д.Балжирдорж, Г.Хишигдулам нар хариуцаж хэрэгжүүлэв.

Удирдлагын академи 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01/18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Удирдлагын академийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Удирдлагын академи нь “Манлайлан ажиллах төгсөгч, мэдлэг тэлэх судалгаа, хөгжилд хөтлөх зөвлөгөөг бид бүтээнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тодорхойлсноор Удирдлагын академийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Сургалт судалгаа
2. Төрийн албаны болон удирдахуйн ухааны шинэ мэдлэг, ур чадварыг түгээх, мэргэжлийн өндөр чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх;

Удирдлагын академийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлагын академийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Удирдлагын академийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Удирдлагын академи санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Удирдлагын академийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Удирдлагын академийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардал нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх тохиромжтой үзүүлэлт гэж үзсэн тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,705.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 47.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, 14 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил илрээгүй байна.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0	
	Дүн	0	0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагааг бүрэн хамруулан авч үзэж чадаагүй тул дараагийн аудитаар авч үзнэ.

Тус байгууллага нь улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ “ гэж заасан боловч аудитын тайлан бэлтгэх хугацааг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гарч байна. Мөн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Удирдлагын академийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 4,916.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас нийт 6,097.4 сая төгрөгийн мөнгөн орлогын гүйцэтгэлтэй буюу 1,181.3 сая төгрөгөөр орлогыг давуулан биелүүлсэн. Мөн 4,741.9 сая төгрөгийн нийт мөнгөн зарлагын гүйцэтгэлтэй буюу 174.2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэлийн 1,218.3 сая төгрөг буюу 20 хувийг Засгийн газрын хэрэг эрхлэх газраас захиалгат сургалт болон тогтмол зардалд урсгал төсвийн санхүүжилтээр, 4,264.1 сая төгрөг буюу 69.9 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 615.0 сая төгрөг буюу 10.1 хувийг туслах үйл ажиллагааны орлогоор тус тус бүрдүүлжээ.

Өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давуулан биелэгдсэн харагдаж байгаа нь Академи жилд 2 удаа хавар, намрын улиралд элсэлт авч хичээл

нь тухайн жилийн 9 дүгээр сараас, 11 дугаар сараас, дараа жилийн 1 дүгээр сараас гэсэн шатлалтайгаар эхэлдэг. Эдгээр шинээр элсэж байгаа оюутан, сонсогчдыг сургалтын төлбөрөө хичээл эхлэхээс өмнө бүрэн төлсөн байхыг шаарддаг тул дараагийн тайлант хугацааны төсөвт тусгасан үндсэн үйл ажиллагааны орлогын эх үүсвэр урьдчилж орж ирдэгтэй холбоотой юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн тайлант хугацаа, хичээлийн жилийн цикл хоорондоо зөрүүтэй байдгаас зайлшгүй урьдчилж орлого ордог. Үүнтэй холбоотойгоор жил бүрийн 9-өөс 12 сард харилцах дансанд тайлант хугацааны зардлын хэмнэлтээс гадна урьдчилж орсон сургалтын төлбөр үлддэг. Туслах үйл ажиллагааны хувьд мөнгөн хөрөнгийн тодорхой хэсгийг хугацаатай хадгаламж үүсгэн хийсэнтэй холбоотойгоор хүүгийн орлого нэмэгдсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Удирдлагын академи Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Удирдлагын академийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Удирдлагын академийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан**3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,259,372,163.11</u>	<u>5,659,064,924.78</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,231,457,741.13	5,587,003,279.79
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,547,849,717.16	2,544,818,259.61
3121	Төгрөг	1,547,849,717.16	2,544,818,259.61
31213	Арилжааны банк дахь харилцах	1,547,849,717.16	2,544,818,259.61
31500	Хадгаламж	2,683,608,023.97	3,042,185,020.18
33	АВЛАГА	955,133,365.64	16,051,127.65
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,021,127.65
335	Бусад авлага	955,133,365.64	15,030,000.00
3351	Байгууллагаас авах авлага	950,103,365.64	10,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,030,000.00	5,030,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,781,056.34	56,010,517.34
351	Түүхий эд материал	11,204,570.00	10,273,350.00
35110	Тусгай зориулалттай материал	11,204,570.00	10,273,350.00
354	Хангамжийн материал	61,576,486.34	45,737,167.34
35410	Бичиг хэргийн материал	21,229,075.00	24,112,330.00
35420	Аж ахуйн материал	40,347,411.34	21,624,837.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,894,845,064.04</u>	<u>7,095,792,553.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,894,845,064.04	7,095,792,553.60
392	Биет хөрөнгө	1,888,807,860.57	5,329,557,553.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,791,034,132.16	4,591,709,565.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	4,696,152,956.40	148,632,883.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,196,000.00	86,196,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	37,047,388.94	46,177,389.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	597,811,115.88	315,437,569.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	454,843,705.49	173,125,582.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	476,702,535.02	570,548,858.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	174,210,104.39	180,188,131.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	165,876,311.57	173,477,138.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	35,858,357.02	38,068,067.61
39217	Ном	169,300,278.18	178,380,475.18
393	Биет бус хөрөнгө	6,037,203.47	1,766,235,000.00
39301	Програм хангамж	36,310,230.00	30,692,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	30,273,026.53	25,702,050.00
39303	Бусад биет бус хөрөнгө	517,892,000.00	2,279,136,300.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	517,892,000.00	517,892,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,154,217,227.15</u>	<u>12,754,857,478.38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,060,507,702.00</u>	<u>2,010,427,238.01</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,060,507,702.00	2,010,427,238.01
4136	Бусад өглөг	71,068,302.00	58,517,184.53
41361	Байгууллагад төлөх өглөг	71,068,302.00	58,517,184.53
414	Урьдчилж орсон орлого	1,989,439,400.00	1,951,786,720.38
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	1,989,439,400.00	1,951,786,720.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,093,709,525.15	10,744,430,240.37
51	Засгийн газрын хувь оролцоо	5,093,709,525.15	10,744,430,240.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,160,774,482.44	3,971,480,882.44
51101	Өмч: - төрийн	2,160,774,482.44	2,160,774,482.44
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		1,761,244,300.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,932,935,042.71	3,443,294,629.29
51210	Өмнөх үеийн үр дүн	2,932,935,042.71	2,932,935,042.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	510,359,586.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	3,379,116,828.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,154,217,227.15	12,754,857,478.38

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,963,675,821.54	5,215,445,991.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,866,260,821.54	3,997,143,091.68
120	Нийтлэг татварын бус орлого	3,866,260,821.54	3,997,143,091.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,846,498,764.54	3,972,935,416.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,846,498,764.54	3,972,935,416.68
120005	Түрээсийн орлого	19,762,057.00	24,207,675.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,097,415,000.00	1,218,302,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,097,415,000.00	1,218,302,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,415,000.00	1,218,302,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,311,754,970.36	4,705,086,401.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,311,754,970.36	4,705,086,401.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,251,805,600.36	4,640,281,271.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,429,699,956.57	2,416,016,702.07
210101	Үндсэн цалин	1,240,908,374.47	1,269,656,567.94
210102	Нэмэгдэл	1,018,087,038.56	987,310,106.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,188,983.54	138,674,027.67
210105	Гэрээт ажлын хөлс	17,515,560.00	20,376,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,421,545.54	281,852,094.32
210201	Тэтгэврийн даатгал	261,421,545.54	281,852,094.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,670,953.36	263,972,900.00
210301	Гэрэл, цахилгаан	68,363,322.00	100,899,736.00
210302	Түлш, халаалт	105,237,024.00	116,326,990.00
210303	Цэвэр, бохир ус	51,070,607.36	46,746,174.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,793,734.21	117,239,652.11
210401	Бичиг хэрэг	31,337,284.00	27,030,980.00
210402	Тээвэр, шатахуун	15,925,000.00	16,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,317,560.21	32,283,866.11
210404	Ном, хэвлэл	7,013,890.00	3,280,502.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,200,000.00	11,730,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	26,234,304.00
2105	Нормативт зардал	14,919,977.00	18,098,512.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,919,977.00	18,098,512.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	473,674,845.00	734,075,489.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,024,140.00	4,484,581.00
210604	Урсгал засвар	468,650,705.00	729,590,908.00
2107	Томилолт, зочны зардал	59,304,304.00	68,411,570.95
210701	Гадаад албан томилолт	28,399,412.00	36,828,021.00
210702	Дотоод албан томилолт	4,501,650.00	8,703,838.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	26,403,242.00	22,879,711.95

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,501,720.67	498,708,121.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,699,044.67	488,926,251.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	883,340.00	862,534.00
210807	Газрын төлбөр	919,336.00	919,336.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,818,564.01	241,906,229.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,891,550.00	3,958,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,248,950.00	81,642,647.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,678,064.01	156,304,882.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,949,370.00	64,805,130.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,949,370.00	64,805,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	6,534,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,949,370.00	58,271,130.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>651,920,851.18</u>	<u>510,359,590.66</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4.08)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>651,920,851.18</u>	<u>510,359,586.58</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>5,277,085,392.24</u>	<u>6,097,442,237.64</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,179,670,392.24	4,879,139,337.64
120	Нийтлэг татварын бус орлого	4,179,670,392.24	4,879,139,337.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,179,670,392.24	4,879,139,337.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,520,368,432.88	4,264,129,384.74
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	598,828,216.96	615,009,952.90
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	60,473,742.40	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,097,415,000.00	1,218,302,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,097,415,000.00	1,218,302,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,415,000.00	1,218,302,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,182,620,170.05</u>	<u>4,525,005,451.98</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,182,620,170.05	4,525,005,451.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,122,820,800.05	4,460,200,321.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,416,999,866.27	2,412,610,817.81
210101	Үндсэн цалин	2,229,123,956.27	2,252,176,508.74
210102	Нэмэгдэл	-	663,367.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,000,000.00	138,674,027.67
210105	Гэрээт ажлын хөлс	22,875,910.00	21,096,914.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,421,545.28	279,688,475.54
210201	Тэтгэврийн даатгал	261,421,545.28	279,688,475.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,670,953.36	263,972,900.00
210301	Гэрэл, цахилгаан	68,363,322.00	100,899,736.00
210302	Түлш, халаалт	105,237,024.00	116,326,990.00
210303	Цэвэр, бохир ус	51,070,607.36	46,746,174.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,578,015.21	92,714,962.11
210401	Бичиг хэрэг	32,606,665.00	28,129,210.00
210402	Тээвэр, шатахуун	15,625,000.00	16,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,372,670.21	32,333,450.11
210404	Ном, хэвлэл	8,773,680.00	3,842,302.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,200,000.00	11,730,000.00
2105	Нормативт зардал	19,603,688.00	17,667,838.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,603,688.00	17,667,838.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	498,675,773.00	736,963,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,059,964.00	6,630,171.00
210602	Тавилга	2,185,600.00	540,948.00
210604	Урсгал засвар	479,430,209.00	729,792,561.00
2107	Томилолт, зочны зардал	62,000,908.00	67,055,154.95

210701	Гадаад албан томилолт	28,734,412.00	37,086,021.00
210702	Дотоод албан томилолт	4,501,650.00	8,703,838.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	28,764,846.00	21,265,295.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	458,012,390.93	494,522,441.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	453,209,714.93	484,740,571.57
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	8,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	883,340.00	862,534.00
210807	Газрын төлбөр	919,336.00	919,336.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,857,660.00	95,004,052.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,041,550.00	4,019,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,816,110.00	90,984,852.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,799,370.00	64,805,130.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,799,370.00	64,805,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	6,534,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,799,370.00	58,271,130.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,094,465,222.19</u>	<u>1,572,436,785.66</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	275,336,230.00	216,891,247.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	275,336,230.00	216,891,247.00
2200	Дотоод эх үүсвэрээр	275,336,230.00	216,891,247.00
222001	Тоног төхөөрөмж	54,780,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	220,556,230.00	216,891,247.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(275,336,230.00)</u>	<u>(216,891,247.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	819,128,992.19	1,355,545,538.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,412,328,748.94	4,231,457,741.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,231,457,741.13	5,587,003,279.79

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,160,774,482.44		2,221,996,521.53	4,382,771,003.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,221,996,521.53	4,382,771,003.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			710,938,521.18	710,938,521.18
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,932,935,042.71	5,093,709,525.15
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,932,935,042.71	5,093,709,525.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,932,935,042.71	5,093,709,525.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		3,379,116,828.64		3,379,116,828.64
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,761,244,300.00			1,761,244,300.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			510,359,586.58	510,359,586.58
2018 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл	3,921,988,782.44	3,379,116,828.64	3,443,294,629.29	10,744,430,240.37

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,916,092,200.00	4,741,896,698.98	174,195,501.02	96.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,916,092,200.00	4,741,896,698.98	174,195,501.02	96.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,831,257,200.00	4,677,091,568.98	154,165,631.02	96.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,496,000,000.00	2,412,610,817.81	83,389,182.19	96.66
210101	Үндсэн цалин	2,294,400,000.00	2,252,839,875.74	41,560,124.26	98.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,000,000.00	138,674,027.67	26,325,972.33	84.04
210105	Гэрээт ажлын хөлс	36,600,000.00	21,096,914.40	15,503,085.60	57.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	299,520,000.00	279,688,475.54	19,831,524.46	93.38
210201	Тэтгэврийн даатгал	299,520,000.00	279,688,475.54	19,831,524.46	93.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,281,500.00	263,972,900.00	22,308,600.00	92.21
210301	Гэрэл, цахилгаан	93,901,500.00	100,899,736.00	(6,998,236.00)	107.45
210302	Түлш, халаалт	129,670,000.00	116,326,990.00	13,343,010.00	89.71
210303	Цэвэр, бохир ус	62,710,000.00	46,746,174.00	15,963,826.00	74.54
2104	Хангамж, бараа материалын зардал	105,238,400.00	99,414,959.11	5,823,440.89	94.47
210401	Бичиг хэрэг	30,310,000.00	28,129,210.00	2,180,790.00	92.81
210402	Тээвэр, шатахуун	16,680,000.00	16,680,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,718,400.00	32,333,450.11	2,384,949.89	93.13
210404	Ном, хэвлэл	11,800,000.00	10,542,299.00	1,257,701.00	89.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,730,000.00	11,730,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	18,450,000.00	17,667,838.00	782,162.00	95.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,450,000.00	17,667,838.00	782,162.00	95.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	952,801,900.00	939,784,030.00	13,017,870.00	98.63
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,277,400.00	53,552,471.00	1,724,929.00	96.88
210602	Тавилга	147,910,000.00	139,669,748.00	8,240,252.00	94.43
210604	Урсгал засвар	749,614,500.00	746,561,811.00	3,052,689.00	99.59
2107	Томилолт, зочны зардал	72,059,400.00	67,055,154.95	5,004,245.05	93.06
210701	Гадаад албан томилолт	39,439,400.00	37,086,021.00	2,353,379.00	94.03
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	8,703,838.00	796,162.00	91.62
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	23,120,000.00	21,265,295.95	1,854,704.05	91.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,460,000.00	496,902,641.57	3,557,358.43	99.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	486,560,000.00	487,120,771.57	(560,771.57)	100.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	8,000,000.00	4,000,000.00	66.67
210804	Тээврийн хэрэгслийн татвар	980,000.00	862,534.00	117,466.00	88.01
210807	Газрын төлбөр	920,000.00	919,336.00	664.00	99.93

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,446,000.00	99,994,752.00	451,248.00	99.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,019,200.00	180,800.00	95.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,246,000.00	95,975,552.00	270,448.00	99.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,835,000.00	64,805,130.00	20,029,870.00	76.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,835,000.00	64,805,130.00	20,029,870.00	76.39
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,290,000.00	6,534,000.00	12,756,000.00	33.87
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	65,545,000.00	58,271,130.00	7,273,870.00	88.90
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,916,092,200.00	6,097,442,237.64	(1,181,350,037.64)	124.03
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,240,611,500.00	1,218,302,900.00	22,308,600.00	98.20
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,240,611,500.00	1,218,302,900.00	22,308,600.00	98.20
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,675,480,700.00	4,879,139,337.64	(1,203,658,637.64)	132.75
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,405,480,700.00	4,264,129,384.74	(858,648,684.74)	125.21
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000,000.00	615,009,952.90	(345,009,952.90)	227.78
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	135.00	135.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	103.00	103.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	135.0	135.0	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	135.00	135.00	-	100.00

